

ХҮНИЙ ЭРХИЙН БОДЛОГО

УДИРТГАЛ

Хүний эрх нь дэлхий нийтийн бөгөөд халдашгүй; хуваагдашгүй; харилцан хамааралтай, бөгөөд харилцан шүтэлцээтэй байдаг. Хүний эрх нь арьсны өнгө, хүйс, яс үндэс, үндэс угсаа, хэл, шашин шүтлэг эсвэл аливаа бусад байдлаас үл хамааран бүх хүн төрөлхтөнд салшгүй заяагдсан билээ. Хүний эрх гэдэгт хүний эрх чөлөөтэйгээр амьдрах эрх, боолчлолоос ангид байх эрх чөлөө, эрүүдэн шүүлт эсвэл айлган сүрдүүлэлтгүйгээр үг хэлэх эрх чөлөө, ажиллах тэгш эрх, бэлэн буй боловсролыг эзэмших эрх болон хүндэтгэлтэй бөгөөд нэр төртэй амьдрах эрх багтдаг. Хүн бүр эдгээр эрхийг ялгаварлан гадуурхалтгүйгээр хүртэх эрхтэй бөгөөд засгийн газар эдгээр эрхийг хүндэтгэх, өндөрт өргөх болон сурталчлах үүрэгтэй.

АЛСЫН ХАРАА

Ногоонтнуудын алсын хараа бол Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал (УННР)-ын зарчмуудыг бүх нийтээр хэрэгжүүлдэг дэлхий ертөнцийг бий болгох билээ. Хувь хүн ба бүлэг хүмүүсийн хүний эрх, үндсэн эрх чөлөөг сурталчлах, хамгаалах болон хүндэтгэх засгийн газрын үүргийг тусгах замаар Олон Улсын Хүний Эрхийн тухай Хуулийг үндэсний болон олон улсын түвшинд дагаж мөрдөхийг урьтал болгосон байдаг. Эдгээр үүргийг Эдийн засаг, Нийгэм, Соёлын Эрхийн тухай Олон Улсын Пакт болон түүний Протоколууд; Иргэний ба Улс Төрийн Эрхийн тухай Олон Улсын Пакт болон түүний Протоколууд; эрх болон эрх чөлөөг хамгаалах олон улсын бусад олон конвенцуудад тусгасан болно. Эдгээр эрхийг орон нутгийн, үндэсний болон олон улсын түвшинд хэрэгжүүлэх шаардлагатай.

ЗОРИЛТ

Зорилт нь арьсны өнгө, хүйс, бэлгийн чиг хандлага эсвэл ялгаварлан гадуурхах бусад арга хэмжээнээс үл хамааран хүний эрхийг хянаж, хамгаалж, хэрэгжүүлдэг үндэсний хүчтэй хүний эрхийн тогтолцоог бий болгох – бөгөөд олон улсын хүний эрхийн байгууллагууд, хууль тогтоомж болон үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, дагаж мөрдөх явдал юм.

ҮЙЛ ХЭРЭГ

Хүний нийтлэг эрхийг үндэс болгон бүх улс орон болон бүх хүмүүс түүнийг хүндэтгэж, хамгаалах ёстой. Эдийн засаг, нийгэм, соёл, байгаль орчин, иргэний болон улс төрийн эрхүүд нь дэлхий нийтийн, харилцан хамааралтай, салшгүй бөгөөд харилцан шүтэлцээтэй байдаг. Улмаар, Ногоонтнууд нь дараах зүйлсийг хэрэгжүүлэх болно –

Хүний Эрхийн Өмнө Хүлээсэн Үүрэг

- Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, Эдийн Засаг, Нийгэм, Соёлын Эрхийн тухай Олон Улсын Пакт, Иргэний болон Улс Төрийн Эрхийн тухай Олон Улсын Пакт, Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын (ILO) конвенцууд, Уугуул Иргэдийн Эрхийн тухай НҮБ-ын тунхаглал, бусад олон улсын баримт бичиг болон эрх, эрх чөлөөг хамгаалах Дэлхийн Ногоонтнуудын Дүрмийг баталж, тэдгээрийг дотоодын хууль тогтоомжинд хэрэгжүүлэх
- Хүний эрхийн мэдлэгийг дээшлүүлэх, тэдний хамгаалалтыг баталгаажуулахаар орон нутгийн хамтын нийгэмлэгүүдтэй хамтран ажиллах

- НҮБ-ын Хүний Эрхийн Комисс болон бусад гэрээт байгууллагуудыг хангалттай нөөцөөр хангах
- Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалд эрүүл байгаль орчны эрх, байгалийн ба соёлын нөөцийн үе дамжсан эрхийг багтаасан нэмэлт өөрчлөлт оруулахыг уриалах.
- Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалаар илэрхийлсэн зарчим, мөн чанарыг бүх нийтээр хүчин төгөлдөр хүлээн зөвшөөрч, дагаж мөрдөж буй эсэхийг баталгаажуулах
- Хүний эрхийн олон улсын бүх конвенц, түүний нэмэлт протоколыг батлах, дагаж мөрдөх
- Олон улсын хүний эрхийн хуулийг засгийн газар заавал дагаж мөрдөх үндэсний хууль тогтоомжоор мөн хамгаалуулж, дотооддоо хүндэтгэж, хамгаалж, сурталчлах явдлыг хангах
- Хүмүүсийн амьдрал ба хүрээлэн буй орчинд нөлөөлөх шийдвэр гаргах үйл явцад оролцох тэгш боломжийг хангах
- Бүх нийтээрээ үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, цугларах эрхийг хангах

Эдийн Засаг, Нийгэм, Соёлын Эрхүүд

- Хөдөлмөрлөх эрх ба нийгмийн хамгааллын эрхийг шударга, таатай нөхцөлөөр хангах
- Адил хөдөлмөр эрхэлсэн тохиолдолд ялгаваргүйгээр адил хэмжээний цалин хөлс авах хүн бүрийн эрхийг хангах
- Амьдралын зохистой түвшин, бие бялдар болон оюун санааны сайн сайхан байдлын хамгийн дээд түвшний стандартуудыг хангах
- Сурч боловсрох эрх, соёлын эрх чөлөө болон шинжлэх ухааны дэвшлийн ашиг тусыг хүртэх эрхийг хангах

Хамтын Нийгэмлэгийн Эрхүүд

- Ноёрхож буй соёл эсвэл эрх баригч засгийн газраас тогтоосон үнэ цэнэ болон амьдралын хэв маягийг хүсээгүйгээр дагаж мөрдөхгүйгээр иргэний хувьд тэгш эрх ба хамтын нийгэмлэгийн үүрэг хариуцлагыг хангуулах боломж олгох
- Бүх хамтын нийгэмлэгүүд нь хүчирхэгжсэн эсвэл хохирсон болон ялгаварлан гадуурхагдсан эсэхээс үл хамааран үндэс угсаа, арьсны өнгө, итгэл үнэмшил, шашин шүтлэг, хүйс, хэл соёл, газарзүйн байршил эвсэл бусад аливаа байдал дээр тулгуурласан ялгаварлан гадуурхалтгүйгээр хуулиар хамгаалагдсан нийгмийн нэг хэсэг мөн болохыг хүлээн зөвшөөрөх
- Хамтын нийгэмлэгүүдтэй түншлэснээр олж авсан хууль ёсны хамгаалалтаар дамжуулан байгалийн эрхийг оршин тогтнох болон цэцэглэн хөгжихийг дэмжих
- Тухайн хамтын нийгэмлэгийн эрхийг зөрчиж болзошгүй үйл ажиллагааг хамтын нийгэмлэгийн хүрээнд гүйцэтгэх саналыг компаниас тавих үед хамтын нийгэмлэг ба түүний орчныг хамгаалах хууль тогтоомжийг гаргах
- Эмэгтэйчүүдийн өөрсдөө шийдвэр гаргах эрхийг өндөр өргөх, ялгаварлан гадуурхалт эсвэл албадлагагүйгээр төрөлтөө өөрсдийн тохиромжтой гэж үзсэн аргаар хянах боломжийг олгох
- Эмэгтэйчүүдийн Эсрэг Ялгаварлан Гадуурхалтыг Устгах тухай Конвенцыг (CEDAW) дэмжих
- Уугуул Иргэдийн Эрхийн тухай НҮБ-ын Тунхаглалыг дэмжих, уугуул иргэдэд өөрсдийн олон улсын байгууллагуудыг үүсгэн байгуулах болон тэдгээрээр дамжуулан ажиллахад дэмжлэг үзүүлэх алхмуудыг хийх

- Уугуул болон Овог Аймгийн Иргэдэд тусгаар тогтнох, газар эзэмших болон амьжиргаагаа залгуулах зорилгоор хүмүүнлэг бөгөөд экологийн хувьд тогтвортой аргуудыг ашиглан уламжлалт ан агнуур хийх болон загасчлах эрхийг олгох замаар тэдний эрхийг дэмжих

Олон Улсын

- Засгийн газруудыг өөрсдийн дипломат ба олон улсын ажил хэргийн үеэр хэлэлцэх асуудлууд дээрээ хүний эрхийн зөрчлийн талаар үргэлж тусгадаг байлгах
- Эсрэг этгээдээ сүрдүүлэх зорилгоор тамлах, хууль бусаар хорих, хувийн мэдээллийг нь хяналтгүйгээр ил болгох эсвэл барууны засгийн газруудад хүчээр шилжүүлэх гэх зэрэг улс төрийн хүчирхийллийг буруушаах
- Улс төрийн зорилгоос нь үл хамааран хүний эрхийг зөрчдөг дарангуйлал болон дэглэмүүдийн эсрэг арга хэмжээ авах
- Улс төрийн хоригдлуудыг чөлөөлөх болон тамлагчдыг цаг алдалгүйгээр шударга ёсны өмнө шүүх
- Хүүхэд, эмэгтэйчүүдийг худалдаалах болон боолчлолын бүх төрөлд цэг тавих
- Олон Улсын Гэмт Хэргийн шүүхийн үүрэг ролийг сурталчлах, бэхжүүлэх болон Ромын Дүрмийг соёрхон батлахад бүх улс үндэстнийг боломжит бүх аргаар хөхүүлэн дэмжих
- Гадаадын улс орнуудад хүний эрх нь зөрчигдөж буй иргэдээ хамгаалах
- Бусад улс орнуудтай зөвшилцөлд хүрсэн олон улсын хүний эрхүүдийг сурталчлах, хүний эрхийг зөрчдөг дэглэм ба засгийн газруудад дипломат ба арилжааны дарамт шахалт үзүүлэх
- Цаазын яланд цэг тавих, бүх тохиолдолд цаазын ялыг эсэргүүцэх болон түүнийг халах талаарх кампанит ажлуудыг дэмжих
- Угсаатны, шашны, нутаг дэвсгэрийн эсвэл хөгжлийн зорилгууд дээр тулгуурлан албадан хөөн гаргах, нутаг дэвсгэрийг эзлэн түрэмгийлэх болон нөөцийг олж авах зорилгоор газар нутгийг их хэмжээгээр эзэмших зэрэг ажиллагаануудад цэг тавих
- Хамтын нийгэмлэгийн эрхийг цаашид хөгжүүлэх, боловсронгуй болон тодорхой болгох хүчин чармайлтуудыг дэмжих, сурталчлах болон олон улсын гэрээ хэлцлүүдэд заавал дагаж мөрдүүлэх

Лавлагаанууд:

<https://www.un.org/en/sections/issues-depth/human-rights/>

<https://www.un.org/en/sections/what-we-do/protect-human-rights/>

<https://www.cagreens.org/platform/human-rights-civil-liberties>

<https://www.cagreens.org/platform/human-rights-civil-liberties>

<https://greens.org.au/policies/human-rights>

https://www.greens.org.nz/human_rights_policy

<https://www.greenparty.ca/en/statement/2019-12-10/green-party-statement-human-rights-day>

<https://policy.greenparty.org.uk/rr.html>

<https://indiagreenparty.org/policies/human-rights/>

https://www.globalgreens.org/brazil2008/declarations/21_commitments